

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь газар, түүний хэвлий, агаарын орон зайд хийгдэх геодези, зураг зүйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн хууль тогтоомж

2.1.Геодези, зураг зүйн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон холбогдох бусад хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“байнгын ажиллагаатай суурин станц” гэж навигацийн хиймэл дагуулын дохио хүлээн авах, хадгалах, боловсруулах, солбицол, өндрөө тухайн агшин бүрд тодорхойлох, мэдээллээ хэрэглэгчдэд түгээх байнгын, тасралтгүй үйл ажиллагаатай иж бүрэн цахим төхөөрөмж бүхий байгууламжийг;

3.1.2.“байр зүйн зураг” гэж дэлхийн гадаргуугийн махиаг тооцон, газар, түүний хэвлий дэх объектыг тусгагт оруулан, тодорхой масштабаар жижгэрүүлэн буулгаж, таних тэмдгээр дүрсэлж, үзүүлэлт, шинж чанарыг нь илэрхийлсэн газрын зургийг;

3.1.3.“байрлалын сүлжээ” гэж солбицлыг нь хэмжиж, тэгшитгэн бодсон геодезийн цэг, тэмдэгтийн олонлогийг;

3.1.4.“газар зүйн нэр” гэж газар, түүний хэвлий дэх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор оноосон болон дэвсгэр нэрийг хамтад нь;

3.1.5.“газрын зураг” гэж газар, түүний хэвлий, огторгуй ертөнцийн бусад бодит биет буюу тэдгээрийн хэсгийг хавтгайд тодорхой масштаб, тусгаг, таних тэмдэг ашиглан жижгэрүүлэн буулгаж дүрсэлснийг;

3.1.6.“газрын зургийн нэг маягийн суурь” гэж жижиг масштабын газрын зураг зохиоход ашиглах газар зүйн нийтлэг өгөгдөл агуулсан зургийг;

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

3.1.7. “геодези” гэж дэлхийн хэлбэр, хэмжээ, түүний гадаргын шилжих хөдөлгөөнийг тодорхойлох, газар, түүний хэвлий дэх хэсгийг зураг болгон буулган дүрслэх зорилгоор од, нар, хиймэл дагуул, геодезийн хэмжих хэрэгслийн тусламжтайгаар цэгийн болон орон зайн биетийн солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгалыг хэмжин, математик боловсруулалт хийх шинжлэх ухааны салбарыг;

3.1.8. “геодезийн цэг, тэмдэгт” гэж геодези, зураг зүйн үйл ажиллагааны үндэс болох солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгал зэрэг орон зайн гурав ба түүнээс дээш хэмжээсээр утга нь тодорхойлогдсон, газар, түүний хэвлий, барилга байгууламж зэрэг хөдөлгөөнгүй биетэд бэхлэгдсэн байнгын төв цэг, түүний дээрх байгууламжийг;

3.1.9. “геодези, зураг зүйн ажлын захиалагч” гэж геодези, зураг зүйн ажил гүйцэтгүүлэх сонирхол бүхий хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;

3.1.10. “геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн систем” гэж геодези, зураг зүйн үйл ажиллагааны хүрээнд аймаг, сум, нийслэл, дүүрэг, улсын болон олон улсын хэмжээнд боловсруулсан өгөгдөл, мэдээллийг цуглуулах, шинэчлэх, нэгтгэн удирдах, зохион байгуулах, хадгалах, хамгаалах хүчин чадалтай, төрийн мэдээллийн бусад сантай харилцан уялдаа бүхий цогц үйл ажиллагаатай цахим тогтолцоог;

3.1.11. “геодезийн сүлжээ” гэж орон зайн гурав ба түүнээс дээш хэмжээст утгыг нь хэмжиж, тэгшитгэн бодсон геодезийн цэг, тэмдэгтийн олонлогийг;

3.1.12. “геодезийн сүлжээний эхлэл цэг” гэж Монгол Улсын байрлал, өндөр, гравиметрийн сүлжээний хэмжилт, тэгшитгэн бодолтод тулгуур болгон ашиглаж байгаа орон зайн гурав ба түүнээс дээш хэмжээст утга бүхий геодезийн цэг, тэмдэгтийг;

3.1.13. “геодезийн хэмжих хэрэгсэл” гэж өнцөг, өндөр, зай, хүндийн хүчний хурдатгал, цэгийн солбицлыг орон зайн гурав ба түүнээс дээш хэмжээсээр тодорхойлох багажийг;

3.1.14. “геоид” гэж далай нам тайван байх үеийн түвшний гадаргууг эх газарт үргэлжлүүлэхэд үүсэх биетийг;

3.1.15. “гравиметрийн сүлжээ” гэж хүндийн хүчний хурдатгалын утгыг нь хэмжиж, тэгшитгэн бодсон геодезийн цэг, тэмдэгтийн олонлогийг;

3.1.16. “гүйцэтгэлийн зураг” гэж шинээр болон өөрчлөн барьж байгуулсан инженерийн барилга байгууламж, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг шинээр хийх, өөрчлөх, нөхөн сэргээх зэрэг газар шорооны ажил хийсэн талбайн бодит байдлыг газрын гадаргуугийн өөрчлөлттэй нь харуулсан байр зүйн болон дэвсгэр зургийг;

3.1.17. “дэвсгэр зураг” гэж газар, түүний хэвлий дэх инженерийн барилга байгууламжийн бодит байршлыг хэмжиж, газрын гадаргуугийн махиаг тооцолгүй батлагдсан түвшинд таних тэмдэг ашиглан том масштабаар дүрсэлснийг;

3.1.18. “дэвсгэр нэр” гэж газар зүйн объектуудыг өөр хооронд нь ялган тодотгох нэрийг;

3.1.19. “жижүүрийн зураг” гэж газрын зургийн агуулгын өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, тэмдэглэсэн зургийг;

3.1.20. “захиалагчийн техникийн хяналт” гэж геодези, зураг зүйн ажлын үр дүн нь геодези, зураг зүйн талаарх хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативын баримт бичгийн шаардлага, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, ажлын даалгаварт нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах мэргэжлийн үйл ажиллагааг;

3.1.21. “зураг зүй” гэж газрын гадаргуугийн дүрс, байгаль, түүний зүй тогтол, нийгмийн үзэгдэл, юмсын хоорондын харилцан хамаарал, учир шалтгааныг шинжлэн дүгнэж, тэдгээрийн цаашдын хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгэм,

эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг харуулсан тодорхой зориулалт, тусгаг, масштаб бүхий газрын зураг, атласыг зохиож, хэвлэх үйл ажиллагааг;

3.1.22. “зурагжуулах” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт агаар, сансрын зураг авах, боловсруулах, төрөл бүрийн масштабтай газрын зураг зохиох үйл ажиллагааг;

3.1.23. “инженерийн барилга байгууламж” гэж Барилгын тухай хуулийн² 4.1.1, 4.1.33, 4.1.35, Эрчим хүчний тухай хуулийн³ 3.1.9, Авто замын тухай хуулийн⁴ 4.1.1, 4.1.11 дэх заалтуудыг хамтад нь;

3.1.24. “кадастрын зураглал” гэж нэгж талбар, түүний гадаргуугийн дээрх, доорх үл хөдлөх эд хөрөнгийн хил заагийн солбицол, өндөр, талбайн хэмжээ, эзлэхүүнийг тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.25. “магадлал” гэж геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, инженерийн барилга байууламжийн зураг төсөлд зориулсан байр зүйн, дэвсгэр, өндөржилтийн, улаан шугамын зураг, ажлын төсөв, даалгавар, сэдэвчилсэн газрын зураг, атласын зохиолтын болон хэвлэлийн эхэд дүгнэлт гаргах, ажлын үр дүнг суурин байдлаар шалгах хараат бус мэргэжлийн үйл ажиллагааг;

3.1.26. “масштаб” гэж газрын зурагт дүрсэлсэн хэрчмийн уртыг газар дээрх бодит урттай нь харьцуулсан харьцааг;

3.1.27. “навигаци” гэж байршил, хөдөлгөөнийг тодорхойлох, удирдан чиглүүлэхтэй холбогдсон цогц үйл ажиллагааг;

3.1.28. “ортофото зураг” гэж агаар, сансрын гэрэл зургийн газрын гадаргуу болон камерын линзний геометрийн гажилтыг засаж тэгш өнцгийн тусгагаар үүсгэсэн ижил масштабтай гэрэл зургийн дүрсийг;

3.1.29. “өндрийн сүлжээ” гэж өндөржилтийг хэмжиж, нормаль өндрийг тэгшитгэн бодсон геодезийн цэг, тэмдэгтийн олонлогийг;

3.1.30. “өндрийн төлөвлөлт” гэж хот, суурин газрын нутаг дэвсгэрт болон инженерийн барилга байгууламжид байгалийн болзошгүй үзэгдлийн нөлөөллийн судалгаа, төлөвлөлтийн шийдлийн тооцооллын үр дүнд газрын гадаргууд гарах өөрчлөлтийг тооцон гаргасан зураг төслийг;

3.1.31. “өндөржилт төлөвлөлтийн зураг” гэж инженерийн барилга байгууламж, гудамж, талбай барьж байгуулах, тохижилт хийх аюулгүй, таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор архитектур, орон зайн төлөвлөлтийн шийдлийн дагуу тухайн газрын гадаргууг өөрчлөн шинэчлэх арга хэмжээг тусгасан, геодезийн хэмжилт, тооцоо, судалгаанд тулгуурлан боловсруулсан зураг төслийг;

3.1.32. “солбицлын дэд тогтолцоо” гэж тухайн нутаг дэвсгэр дэх геодезийн сүлжээний цэгт үндэслэн, физик гадаргууд тохирсон хавтгай дээр солбицлын утгыг тодорхойлсон дүрмийг;

3.1.33. “солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо” гэж геодезийн цэг, тэмдэгтийн солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгалын тоон утгыг геодезийн сүлжээний эхлэл цэгээс харьцуулан тогтоох дүрмийг;

3.1.34. “солбицол, өндөр, гравиметрийн тогтолцооны эрин” гэж геодезийн хэмжилт, ажиглалт, судалгаанд одот ертөнцийн таталцал, түлхэлцэл, агаар мандлын соронзон идэвхжилт, дэлхийн дотоод, гадаад хүчний үйлчлэлийн хувьсах үйл явцын өөрчлөлтийг тооцоолсон цаг хугацааны утгыг;

3.1.35. “сэдэвчилсэн газрын зураг, атлас” гэж газрын зургийн нэг маягийн суурь ашиглан зохиосон тухайлсан агуулга бүхий газрын зураг, атласыг;

3.1.36. “тэг тэнхлэг” гэж Барилгын тухай хуулийн 4.1.40-д заасныг;

² Барилгын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дүгээрт нийтлэгдсэн.

³ Эрчим хүчний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2001 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Авто замын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

3.1.37. “улаан шугам” гэж өөрчлөлт оруулах, эсхүл шинээр байгуулахаар төлөвлөж байгаа инженерийн барилга байгууламж, тусгай хэрэгцээний болон нийтийн эдэлбэр газар нутгийн хил хязгаарыг харуулсан шугамыг;

3.1.38. “Үндэсний референц эллипсоид” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийн геоид гадаргууд хамгийн их нийцтэй байхаар тодорхойлж сонгосон эллипсоидыг;

3.1.39. “хаягийн зураг” гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр газар нутаг, гудамж, зам, талбай, үйлдвэр, аж ахуйн нэгж, хотхон, хороолол, төлөвлөлтгүй суурьшсан хэсэг зэрэгт харьяалагдах үл хөдлөх эд хөрөнгийн нэр, дугаар, байршлыг дүрсэлсэн, байр зүйн зурагт суурилсан сэдэвчилсэн газрын зургийг.

4 дүгээр зүйл. Геодези, зураг зүйн салбарт баримтлах зарчим

4.1. Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг мөрдөхийн зэрэгцээ дараах зарчмыг баримтална:

4.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь геодезийн хэмжилт, газрын зургаар баталгааждаг байх;

4.1.2. геодези, зураг зүйн үйл ажиллагааны зохицуулалт, бүртгэл, зөвшөөрөл, хяналт, шалгалт олон нийтэд ил тод, нээлттэй байх;

4.1.3. геодези, зураг зүйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдлыг хангах;

4.1.4. геодези, зураг зүйн үйл ажиллагааг солбицол, өндөр, гравиметр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд гүйцэтгэх;

4.1.5. геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологи, инновац нэвтрүүлж, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

5 дугаар зүйл. Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, хэрэгжилт

5.1. Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дараах ажил хамаарна:

5.1.1. үндэсний референц эллипсоид, солбицол, өндрийн тогтолцоо, геоидын өндрийн загвар, тусгагийг тодорхойлох, нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, солбицлын тогтолцоо хооронд хөрвүүлэх, солбицол, өндрийн утгын цаг хугацааны өөрчлөлтийг тогтоох, дэлхийн хэлбэр, хэмжээ, түүний хүндийн хүчний таталцлын орныг тодорхойлох, нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ, хамгийн өндөр, нам цэг, төв цэг, захын цэгүүдийн байршил, хоорондын зайг тодорхойлох;

5.1.2. газар түүний хэвлий дэх цэг, биетийн солбицол, өндрийг тодорхойлох, тэдгээрийн орон зайн харилцан байршлыг нь тогтоох зорилгоор геодезийн хэмжилт, боловсруулалт хийх;

5.1.3. улсын геодезийн байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээ байгуулах, сүлжээний нарийвчлалыг сайжруулах;

5.1.4. геодезийн цэг, тэмдэгтийг байгуулах, сэргээх, тоолох, бүртгэх, хадгалах, хамгаалах, шалгах;

5.1.5.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг зурагжуулах, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн газрын зураг зохиох, шинэчлэх;

5.1.6.агаар, сансраас газрын зураг авах, фотограмметрийн боловсруулалт хийх;

5.1.7.Монгол Улсын хилийн тухай хуулийн⁵ дагуу улсын хилийг тодорхойлох, хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг тогтоох, шалгах, хоорондын зайг тодорхойлох, хилийн шугамын дагуу газрын зураг үйлдэх;

5.1.8.засаг захиргааны нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгийн байршил, солбицлыг тодорхойлох, тусгай хэрэгцээний газар, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай, бүх төрлийн кадастрын хил заагийн эргэлтийн цэгийн байршлыг газар дээр нь геодезийн хэмжилтээр тогтоох, солбицлын жагсаалт, хилийн цэсийн зураг үйлдэх;

5.1.9.геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хөтлөх;

5.1.10.үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг суурь өгөгдөл, мэдээллээр хангах;

5.1.11.сургалт, нийтийн хэрэгцээнд зориулсан сэдэвчилсэн газрын зураг, атлас, үндэсний атлас зохиох, хэвлэх;

5.1.12.газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, хамрах хүрээг тогтоох, газар зүйн нэрийн зураг зохиох, хувийн хэрэг хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх;

5.1.13.газар зүйн нэрийг зөв бичих, хөрвүүлэх, газрын зурагт тусгах, нэрийн мэдээллийн сан хөтлөх, тайлбар толь бичиг, жагсаалт, лавлах боловсруулж хэвлэх, лавлагаа гаргах, газар зүйн нэрийн зураг, альбом хэвлэж, нийтийн хүртээл болгох;

5.1.14.бүх төрлийн кадастрын зураглал үйлдэх;

5.1.15.газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, инженерийн барилга байгууламж төлөвлөх, барьж байгуулахад зориулсан газрын зураг зохиох, шинэчлэх, орон зайн мэдээллийн сан үүсгэх;

5.1.16.инженер геологи, гидрогеологи, геологи, уул уурхай, геофизикийн хайгуулын геодезийн хэмжилт хийх, газрын зураг зохиох, шинэчлэх, мэдээллийн сан бүрдүүлэх;

5.1.17.хот байгуулалтын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх зорилгоор тусгай зориулалтын геодезийн торлол, өндөржилт төлөвлөлтийн зураг төсөл зохиох;

5.1.18.геодези, зураг зүйн салбарт шинжлэх ухааны туршилт, судалгаа хийх, программ хангамж, хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмж зохион бүтээх, үйлдвэрлэл, үйлчилгээнд орчин үеийн техник, технологи, инновац нэвтрүүлэх;

5.1.19.үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх;

5.1.20.өндөр уулсын ноёлох оргилын солбицол, өндрийг тодотгон тогтоох, экологийн тогтолцооны газрын зураг зохиох, шинэчлэх;

5.1.21.усны хайгуул судалгааны ажлын геодезийн хэмжилт, зураглал үйлдэх, нуур, гол, гол мөрний урсац бүрэлдэх, усны эх үүсвэр, ус хангамжийн эх үүсвэр, усан сан, тэдгээрийн ёроолын зураглал, усан замын газрын зураг зохиох, шинэчлэх, хэвлэх;

5.1.22.хаягийн зураг зохиох, хаягийн тэмдэг, тэмдэглэгээг зураг төслийн дагуу байршуулах;

⁵Монгол Улсын хилийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

5.1.23.бүх төрлийн газрын зурагт жижүүрийн хөтлөлт хийх;

5.1.24.далан, гүүр, хонгилын мониторинг, барилга, байгууламжийн хэв гажилтыг тодорхойлох;

5.1.25.геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах, тохируулах, жишилтийн полигоныг байгуулах, ажиллуулах;

5.1.26.газар, түүний хэвлий дэх инженерийн барилга байгууламжийн тэг тэнхлэг, улаан шугамыг газарт буулгах, барьж байгуулах, ашиглалтын үеийн геодезийн хэмжилт хийх, тэдгээрийн гаднах, доторх геометр хэмжээг тодорхойлох;

5.1.27.соёлын өвийг хайх, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлах чиглэлээр хийгдэх геодезийн хэмжилт, зураглалын ажил хийх;

5.1.28.газрын хэвлий дэх геодезийн хэмжилт, зураглалын ажил хийх, өрөмдлөгийн цооног холбох;

5.1.29.байнгын ажиллагаатай суурин станц байгуулах, ажиллуулах, дэлхийн царцдасны хэвтээ, босоо хөдөлгөөний өөрчлөлтийг судлах, солбицол, өндөр, гравиметрийн тогтолцооны эрин хоорондын хөрвүүлэлт хийх;

5.1.30.хиймэл дагуулын лазерын хэмжилт хийх, хэт урт суурь шугам хэмжих, хиймэл дагуулын тохируулга хийх станц байгуулах, ажиллуулах;

5.1.31.том, дунд масштабын газрын зураг зохиох, шинэчлэх зорилгоор хиймэл дагуулын өндөр дүрслэх чадвартай олон сувгийн мэдээ хүлээн авах суурин станц байгуулах, ажиллуулах;

5.1.32.цахилгаан соронзон долгионы янз бүрийн гэрлийн мужид авсан хиймэл дагуулын мэдээг геодезийн өгөгдөлд хөрвүүлэх;

5.1.33.геодезийн хэмжих хэрэгслийг засварлах, тохируулга хийх;

5.1.34.нутаг дэвсгэрийн хэмжээнд цаг дамжуулах, газар нутгийн байрлалтай харьцангуйгаар цагийн явалтыг тооцон гаргах, навигаци, лазерын хиймэл дагуулын өгөгдлийг засварлах, хэт урт суурь шугамын тэгшитгэн бодолтод ашиглах;

5.1.35.агаар, сансраас дэлхийг судлах техник технологийг судлах, хөгжүүлэх, ашиглах, зайнаас тандан судлалын хиймэл дагуулын судалгаа, хөгжүүлэлтийг хийхэд оролцох, сансрын техник технологийн мэдээллийг боловсруулан ашиглах;

5.1.36.геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, тайлан боловсруулах;

5.1.37.гүйцэтгэлийн зураглал үйлдэх.

5.2.Геодези, зураг зүйн үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.2.1.энэ хуулийн 5.1 дэх хэсгийн 5.1.1, 5.1.7, 5.1.9, 5.1.10, 5.1.13, 5.1.25, 5.1.29, 5.1.34, 5.1.35-т заасан үйл ажиллагааг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

5.2.2.энэ хуулийн 5.2.1, 5.1.19-д зааснаас бусад үйл ажиллагааг хүн, хуулийн этгээдийн захиалгаар геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.

6 дугаар зүйл.Монгол Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажил

6.1.Монгол Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажилд энэ хуулийн 5.1.7, 5.1.19-д заасан ажлыг хамааруулан ойлгоно.

6.2.Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлыг Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ.

6.3.Гамшгаас урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үед хийгдэх геодези, зураг зүйн ажлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ.

6.4.Энэ хуулийн 5.1.7-д заасан ажлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хил хамгаалалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран Монгол Улсын хилийн тухай хуулийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл.Солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо

7.1.Монгол Улс дэлхийн хүндийн төвд эхлэлтэй гурав болон түүнээс дээш хэмжээст солбицол, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоо, солбицлын дэд тогтолцоотой байна.

7.2.Нийслэл, сумын төв, хот, тосгон, суурин газар бүр солбицлын дэд тогтолцоотой байна.

7.3.Солбицлын дэд тогтолцоог геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар батлуулж, солбицлын нэгдсэн тогтолцоо хоорондын харилцан хөрвүүлгийн утгыг тодорхойлсон байна.

7.4.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг зурагжуулахад зориулсан газрын зургийг солбицлын нэгдсэн тогтолцоонд гүйцэтгэнэ.

7.5.Хот байгуулалт, уул уурхайн ашиглалт, ашигт малтмалын нөөц тооцоолол, инженерийн барилга байгууламжийн төсөл, тооцоонд шаардлагатай геодезийн хэмжилт, том масштабын дэвсгэр зураглалыг солбицлын дэд тогтолцоонд гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл.Геодезийн сүлжээ

8.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн хэлбэр хэмжээ, түүний хэвтээ болон босоо шилжилт хөдөлгөөнийг шинжлэн судлахад байрлалын, өндрийн, гравиметрийн сүлжээг байгуулна.

8.2.Монгол Улсын геодезийн сүлжээг дэлхийн хүндийн төвд эхлэлтэй гурав болон түүнээс дээш хэмжээст солбицол, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоонд байгуулна.

8.3.Монгол Улсын геодезийн сүлжээний бүрэлдэхүүнд байнгын ажиллагаатай суурин станц багтана.

8.4.Монгол Улсын геодезийн байрлалын сүлжээг 6-8 жил тутамд, өндрийн болон гравиметрийн сүлжээг 15 жил тутамд, 6 түүнээс дээш баллын бүсэд газар хөдлөлт болсон тохиолдолд тухай бүр давтан хэмжиж шинэчилнэ.

8.5.Монгол Улсын геодезийн сүлжээний бүтэц, түүнийг байгуулах, геодезийн цэг, тэмдэгтэд тавих шаардлагыг геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгээр тогтооно.

9 дүгээр зүйл.Геодезийн цэг, тэмдэгт

9.1.Геодезийн цэг, тэмдэгт, улсын болон орон нутгийн төсөв, олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр байгуулсан байнгын ажиллагаатай суурин станц нь төрийн өмч байна.

9.2.Геодезийн цэг, тэмдэгтийг байгуулах, ашиглахад холбогдох норм, нормативын баримт бичгийг баримтална.

9.3.Геодезийн цэг, тэмдэгтийн хамгаалалтын бүс нь хот, суурин газарт цэгийн төвөөс 1.5 метр, бусад газарт 3 метр бүхий газрыг хамарна.

9.4.Геодезийн цэг, тэмдэгтийн өгөгдөл, мэдээллийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан болон системд төвлөрүүлнэ.

9.5.Улсын геодезийн сүлжээний байнгын ажиллагаатай суурин станцын хиймэл дагуулаас хүлээн авч байгаа долгионыг хаах эсвэл ойлгох, долгионыг сарниулагч байгууламж, төхөөрөмжийг түүний хамгаалалтын бүсэд байрлуулахыг хориглоно.

9.6.Энэ хуулийн 8.3-д заасан байнгын ажиллагаатай суурин станцын хамгаалалтын бүсийг Засгийн газар тогтооно.

9.7.Геодезийн цэг, тэмдэгтийг устгах, гэмтээх, цэгийн төвийн хөдөлгөөнгүй байдал, хэмжилт хийх, түүнд чөлөөтэй хүрч очих нөхцөлийг алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

9.8.Хүн, хуулийн этгээд нь геодезийн цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ дор дурдсан байгууллагаар уламжлан геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэн зөвшөөрөл авна:

9.8.1.улсын хилийн зурваст хилийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

9.8.2.улсын тусгай хэрэгцээний газарт газар эзэмшигч байгууллага;

9.8.3.энэ хуулийн 9.8.1, 9.8.2-т зааснаас бусад газарт сум, дүүргийн Засаг дарга.

9.9.Геодезийн цэг, тэмдэгтийг зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлага гарвал түүнийг нөхөн сэргээх зардлыг хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээд хариуцна.

9.10.Геодезийн цэг, тэмдэгт байрлаж байгаа газар, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь түүнийг хамгаалах, геодезийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

9.11.Нутаг дэвсгэртээ байгаа геодезийн сүлжээний эхлэл цэг болон цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцаж цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулсан тохиолдолд геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.

9.12.Хилийн зурваст байгаа геодезийн цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд хил хамгаалах байгууллага хяналт тавьж цэг, тэмдэгтийг гэмтээсэн, устгасан, хэмжилт хийх нөхцөлийг алдагдуулсан тохиолдолд геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.

9.13.Улсын тусгай хэрэгцээний газарт байгаа геодезийн сүлжээний эхлэл цэг болон цэг, тэмдэгтийн бүрэн бүтэн байдалд тухайн сум, дүүргийн Засаг дарга, тусгай хэрэгцээний газрын хамгаалалт хариуцсан захиргааны дарга, хилийн зурвас газарт хил хамгаалах байгууллагын харьяа тусгай ангийн дарга хяналт тавина.

9.14.Геодезийн цэг, тэмдэгтийн ач холбогдлыг сурталчлах, иргэдийг мэдээллээр хангах, хамгаалах, ашиглах үйл ажиллагааны журам, зааврыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж мөрдүүлнэ.

9.15.Инженерийн барилга байгууламж болон газар хөдлөлтийн 6 түүнээс дээш баллын бүсэд геодезийн хяналтын цэг байгуулна.

10 дугаар зүйл.Газрын зургийн төрөл, ангилал, агуулга, нарийвчлал, хэрэглээ

10.1.Газрын зургийг агуулга, хэрэглээнээс хамааруулан дараах төрөлд хуваана:

- 10.1.1.байр зүйн зураг;
- 10.1.2.дэвсгэр зураг;
- 10.1.3.хаягийн зураг;
- 10.1.4.гүйцэтгэлийн зураг;
- 10.1.5.кадастрын зураг;
- 10.1.6.газар зүйн нэрийн зураг;
- 10.1.7.ортофото зураг;
- 10.1.8.сэдэвчилсэн газрын зураг, атлас;
- 10.1.9.жижүүрийн зураг;
- 10.1.10.өндөржилт төлөвлөлтийн зураг;
- 10.1.11.бусад.

10.2.Газрын зургийг масштабаар нь том, дунд, жижиг гэж дараах байдлаар ангилна:

- 10.2.1.том масштабын газрын зурагт 1:100, 1:200, 1:500, 1:1000, 1:2000, 1:5000;
- 10.2.2.дунд масштабын газрын зурагт 1:10000, 1:25000, 1:50000, 1:100000, 1:200000;
- 10.2.3.жижиг масштабын газрын зурагт 1:500000 ба түүнээс жижиг масштаб хамаарна.

10.3.Газрын зургийн масштабыг зориулалтаас нь хамааруулан дараах байдлаар сонгож хэрэглэнэ:

- 10.3.1.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг зурагжуулахад 1:25000, 1:50000, 1:100000, 1:500000, 1:1000000;
- 10.3.2.улсын хэмжээний байгаль, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийг дүрсэлсэн сэдэвчилсэн газрын зураг, атласт жижиг масштабыг;
- 10.3.3.улсын болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, мужлалын зураг зохиоход 1:500000, 1:1000000;
- 10.3.4.аймаг, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлтөд 1:25000, 1:50000, 1:100000;
- 10.3.5.бэлчээр, усны нөөцийн тархалтад 1:50000, 1:100000;
- 10.3.6.геологийн ерөнхий эрэл хайгуулын судалгаанд 1:25000, 1:50000, нарийвчилсан судалгаанд 1:2000;
- 10.3.7.газар тариалан, авто зам, эрчим хүч, хийн хоолой, төмөр замын трассын төлөвлөлт, хүрээлэн буй орчин, усны сан бүхий газрын судалгаанд 1:10000, 1:25000;
- 10.3.8.хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар хөдлөлийн бичил мужлалын зураглалд 1:1000, 1:5000;
- 10.3.9.хот, суурин газрын байр зүйн болон дэвсгэр зурагт 1:500;
- 10.3.10.хот, суурин газрын хаягжуулалтад 1:1000, бусад газрын хаягжуулалтад 1:25000, 1:100000;
- 10.3.11.газар зүйн нэрийн зураг зохиоход 1:25000, 1:100000;

10.3.12.хот, суурин газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, барилгажилтын төсөл, хот байгуулалт, барилгад ашиглах байгаль орчин, инженер геологи, хөрс, буурь, инженерийн бэлтгэл арга хэмжээ, үерийн хамгаалалт, цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбайн тохижилтын ажлын зураглалд 1:1000;

10.3.13.газар доорх болон гүүрэн байгууламж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шугамын суурилуулалтад 1:50-1:200;

10.3.14.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 1:1000000, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 1:100000, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 1:5000, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 1:25000, 1:100000, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 1:1000, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 1:5000, 1:10000, 1:25000, 1:100000;

10.3.15.инженерийн барилга байгууламжийн зураг төсөл, нарийвчилсан төлөвлөлтөд 1:100, 1:200, 1:500, 1:1000;

10.3.16.аймаг, сум, нийслэл, дүүргийн хилийн цэсийн зураглалд 1:25000, 1:100000, баг, хорооны хил заагийн зураглалд 1:1000.

10.4.Газрын зургийн нарийвчлал нь байрлалаараа масштабын 0.1 мм, өндрийн хувьд үеийн өндрийн гуравны нэгээс багагүй байна.

10.5.Газрын зургийн таних тэмдгийг стандартаар, газрын зураг зохиох үйл ажиллагаа, агуулга, тавигдах шаардлагыг техникийн зохицуулалт, норм дүрмээр тогтооно.

10.6.Газрын зургийг зохиоход геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд хадгалагдаж байгаа газрын зургийн нэг маягийн суурь, орон зайн өгөгдөл, мэдээллийг суурь болгон ашиглана.

10.7.Байр зүйн болон дэвсгэр зургийг зориулалтаар нь тусгай, нийтийн зориулалтын гэж дараах байдлаар ангилна:

10.7.1.тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зураг нь төрийн болон албаны нууцад хамаарсан мэдээллийг агуулсан, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад зориулсан байна;

10.7.2.нийтийн зориулалтын байр зүйн болон дэвсгэр зураг нь энэ хуулийн 10.7.1-д заасан мэдээллийг агуулаагүй байна.

10.8.Тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зурагт дүрслэгдэх нууцад хамаарах мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулна.

10.9.Нийтийн зориулалтын байр зүйн зургийн агуулга, тавигдах шаардлагыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

10.10.Монгол Улсын Үндэсний атласыг 5 жил тутамд, улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан дунд масштабын байр зүйн зургийг 10 жил тутамд, том масштабын байр зүйн болон дэвсгэр зургийг нийслэлд хоёр жил тутамд, бусад хот, суурин газар, улсын хилийн боомтын суурьшлын бүсэд гурван жил тутамд шинэчилнэ.

10.11.Ортофото зургийг том масштабын байр зүйн болон дэвсгэр зургийн нарийвчлалаар нийслэлд жил тутам, сумын төв, суурин газарт гурван жил тутам гүйцэтгэнэ.

10.12.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дунд болон жижиг масштабын газрын зургийн жижүүрийн зураг, нэг маягийн суурийн нэмэлт, өөрчлөлтийг жил бүр хөтөлнө.

10.13.Дэвсгэр зургийг солбицлын дэд тогтолцоонд газар нутгийн хязгаарлагдмал талбайд том масштабаар үйлдэнэ.

10.14.Хилийн бүсэд агаараас газрын зураг авахдаа хил залгаа улсын холбогдох байгууллагад дипломат шугамаар мэдэгдэнэ.

10.15.Тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зураг, үндэсний атлас зохиох, шинэчлэх, тэдгээрийг тоон хэлбэрт шилжүүлэх, хэвлэх, ашиглах асуудлыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь холбогдох бусад төрийн захиргааны байгууллагатай хамтран Засгийн газрын баталсан журмын дагуу зохион байгуулна.

10.16.Газрын зургийн масштабыг томруулан зохиох, хэвлэх, газар нутгийн хэлбэрийг гажуудуулах, цаасан болон цахим газрын зургийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй хуулбарлан ашиглахыг хориглоно.

10.17.Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн зохиосон зураг зүйн бүтээлийг хуулбарлах, олшруулах, хэвлэх, худалдан борлуулахыг хориглоно.

10.18.Энэ хуулийн 5.1.8-д заасан хил заагийн эргэлтийн цэгийн солбицлыг геодезийн хэмжих хэрэгсэл ашиглаж 10 см-ээс ихгүй үнэмлэхүй алдаатай тодорхойлж баталгаажуулна.

10.19.Энэ хуулийн 5.1.8-д заасан хил заагийн эргэлтийн цэгийн солбицлыг газрын зургаас хэмжиж тодорхойлохыг хориглоно.

11 дүгээр зүйл. Газар зүйн нэр

11.1.Газар зүйн нэрд дараах объектын нэр хамаарна:

11.1.1.эх газар, далай, тэнгис, уул, нуруу, булан, тохой, арал, хойг, хээр тал, говь, цөл, гол, мөрөн, нуур, тойром, булаг, шанд зэрэг физик газар зүйн объект;

11.1.2.улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот, тосгон, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэр;

11.1.3.хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, гүүр, усан сан, худаг, цөөрөм, суваг, хөшөө, түүх, соёлын дурсгалт газар, гудамж, зам, талбай, хотхон, хороолол, барилга байгууламж, хөдөө аж ахуй, уурхай, үйлдвэр, оршуулгын газар, байгууламж, тээвэр, холбоо зэрэг бусад объект.

11.2.Газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоохдоо лавлагааны болон түүхийн эх сурвалжид үндэслэх бөгөөд эх сурвалж байхгүй бол нутгийн уугуул иргэд, түүх, угсаатан зүй, монгол хэлний эрдэмтэн судлаачдын санал, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэнэ.

11.3.Хүн, хуулийн этгээдийг газар зүйн албан ёсны нэрийн тухай мэдээлэл, түүхчилсэн лавлагаагаар хангах, газар зүйн нэрийг зөв бичих, хэрэглэх, мөрдүүлэх, хамгаалах асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран цахим системээр дамжуулан зохион байгуулна.

11.4.Физик газар зүйн болон хүний үйл ажиллагаагаар бий болсон объектыг нэрлэхэд дараах зарчим баримтална:

11.4.1.ойролцоо орших өөр төрлийн объектуудын оноосон нэр нь ижил байж болох;

11.4.2.газар зүйн хуучин нэрээр нь зүг чиг, өнгө, хэлбэр, дүрс, хэмжээ, цаг хугацааны тодотголтой нэрлэж болох;

11.4.3.хот, суурин газрын нэртэй давхцуулахгүй байх;

11.4.4.хүний үйл ажиллагаагаар бий болсон объектыг нэрлэхдээ түүний ойролцоо орших физик газар зүйн объектын оноосон нэрэнд үндэслэх.

11.5.Газар зүйн нэрийг дараах онцгой тохиолдолд өөрчилж болно:

11.5.1.адил төрлийн хэд хэдэн объектын ижил нэр нь зам, тээвэр, харилцаа холбоо, бусад байгууллагын ажилд хүндрэл учруулахаар байвал;

11.5.2.түүхэн уламжлалт нэрийг сэргээх хүсэлт тавьсан;

11.5.3.тухайн объектын мөн чанарт тохирохгүй, этгээд хэллэгээр, монгол хэлнээс бусад хэл дээр нэрлэгдсэн байвал.

11.6.Шинээр нэрлэх, өөрчлөх газар зүйн нэр дараах шаардлагыг хангасан байна:

11.6.1.хүрээлэн буй орчин, газар зүйн объектын тодорхой шинж, түүх, соёл, ахуйн онцлогийг тусгасан байх;

11.6.2.монгол хэл, бичгийн дүрэм, үг хэллэгт нийцсэн гурваас илүүгүй үгээс бүтсэн байх;

11.6.3.газар орны онцлог, түүхэн үйл явдал, ард түмний ёс заншил, уламжлал зэргийг харгалзах.

11.7.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2 дахь хэсэгт заасан газар зүйн нэрийг Засгийн газар Улсын Их Хурлаар батлуулахаар өргөн мэдүүлнэ.

11.8.Улсын Их Хурлаар батлагдах газар зүйн нэрийн саналыг хэлэлцэж зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус газар зүйн нэрийн Үндэсний зөвлөл Засгийн газрын дэргэд, орон тооны бус газар зүйн нэрийн салбар зөвлөл аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллана.

11.9.Газар зүйн нэрийн Үндэсний болон салбар зөвлөлийг дараах шаардлагад нийцүүлэн байгуулна:

11.9.1.газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд 4 жилийн хугацаатай томилно;

11.9.2.газар зүйн нэрийн Үндэсний зөвлөл үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хил хамгаалах, архив, боловсрол, соёл, барилга, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, геологи, уул уурхай, хөдөө аж ахуй, байгаль орчин, гадаад харилцаа, зам, тээвэр, харилцаа холбоо, шинжлэх ухааны судалгааны, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл болон Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн гишүүдээс бүрдэх ба тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна;

11.9.3.газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ;

11.9.4.газар зүйн нэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга батална.

11.10.Энэ хуулийн 11.1.3 дахь хэсэгт заасан нэрийг газар зүйн нэрийн салбар зөвлөлийн саналыг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

11.11.Энэ хуулийн 11.1.1-д заасан газар зүйн нэрийг 15 жил тутамд, 11.1.3-т заасан газар зүйн нэрийг 4 жил тутамд тодотгон баталгаажуулна.

11.12.Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, толь бичиг, лавлах боловсруулж хэвлэх, шинээр өгсөн нэр болон өөрчлөгдсөн нэрийг газрын зурагт тусгах асуудлыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

11.13.Гадаад хэл дээр зохиох газрын зураг, атлас, сурах бичиг, ном товхимол, илтгэлд газар зүйн нэрийг стандартын дагуу латин үсэгт хөрвүүлж бичнэ.

11.14.Газар зүйн оноосон нэрийг орчуулахгүй, дэвсгэр нэрийг орчуулж болно.

11.15.Монгол хэл дээр зохиох дэлхийн газрын зурагт газар зүйн албан ёсны гадаад нэрийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч ашиглана.

11.16.Газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, ард иргэдийн дунд таниулан сурталчлах, хэрэглэж мөрдөх, хойч үедээ

өвлүүлэх асуудлыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ.

11.17.Батлагдсан газар зүйн нэрийг албан ёсны баримт бичиг, газрын зурагт өөрчлөн хэрэглэхийг хориглоно.

11.18.Газар зүйн нэрийг зөв бичих, хөрвүүлэх, лавлагаа гаргах асуудлыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шинжлэх ухааны болон холбогдох бусад байгууллагын саналыг авч хэрэгжүүлнэ.

11.19.Хүн, хуулийн этгээд газар зүйн нэрийг өөрчлөх, шинэ нэр өгөх хүсэлтийг энэ хуулийн 11.4, 11.5, 11.6-д заасан шаардлагад нийцүүлэн геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, тухайн шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана.

12 дугаар зүйл.Геодези, зураг зүйн зөвлөх үйлчилгээ

12.1.Геодези, зураг зүйн салбарын мэргэжлийн зөвлөх үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ:

12.1.1.геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл зохиох;

12.1.2.геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах, шүүмж хийх, хянан тохиолдуулах;

12.1.3.геодези, зураг зүйн ажилд техникийн хяналт, зураг төсөлд магадлал хийх чанарт зөвлөмж, дүгнэлт гаргах;

12.1.4.техник, технологийн үйлдвэрлэлийн туршилт хийх, технологийн горим тогтоох;

12.1.5.геодезийн хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн угсралт, оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт хийх ажлын технологи, аргачлал тогтоох, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах;

12.1.6.олон улсын болон улсын чанартай инженерийн барилга байгууламжийн угсралт, ашиглалтын үеийн геодезийн хэмжилт хийх.

13 дугаар зүйл.Геодези, зураг зүйн салбарын даатгал

13.1.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд оролцогч учирч болзошгүй эрсдэлийг даатгуулж болно.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасны дагуу даатгуулах тохиолдолд даатгалыг захиалагч, гүйцэтгэгч урьдчилан тохиролцож геодези, зураг зүйн ажил гүйцэтгэх гэрээнд тусгана.

13.3.Геодези, зураг зүйн ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулж болно.

13.4.Геодези, зураг зүйн ажил олгогч нь ажилтнуудыг амь насны даатгалд даатгуулж болно.

14 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг

14.1.Геодези, зураг зүйн үйл ажиллагааг доор дурдсан норм, нормативын баримт бичгээр зохицуулна:

14.1.1.геодези, зураг зүйн техникийн зохицуулалт, норм дүрэм;

14.1.2.геодези, зураг зүйн дүрэм, журам;

14.1.3.стандарт.

14.2.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд энэ хуулийн 14.1.1-д заасан геодези, зураг зүйн техникийн зохицуулалт, норм дүрмийг заавал мөрдөнө.

14.3.Геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгээр геодези, зураг зүйн үйл ажиллагааны техникийн нарийвчилсан нөхцөл, шаардлагыг тогтооно.

14.4.Геодези, зураг зүйн үйл ажиллагаанд дагаж мөрдөх техникийн зохицуулалт, стандартыг боловсруулах, батлах, ашиглах, тохирлын гэрчилгээ олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

14.5.Геодези, зураг зүйн норм нормативын баримт бичиг боловсруулах, хэвлэж олшруулах, сурталчлах, геодезийн хэмжих хэрэгслийг баталгаажуулах үйл ажиллагааг сайжруулах ажлыг санхүүжүүлэх зориулалт бүхий Геодези, зураг зүйн норм, нормативын сантай байна.

14.6.Геодези, зураг зүйн норм, нормативын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

14.6.1.геодези, зураг зүйн ажлын төсөвт өртгийн нэг хувиар тооцсон орлого;

14.6.2.геодезийн хэмжих хэрэгслийг баталгаажуулсны орлого;

14.6.3.геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох зорилгоор өгсөн хандив.

14.6.4.геодези, зураг зүйн төрийн хяналт, шалгалт, захиалагчийн техникийн хяналтаас олох орлого.

14.6.5.геодези, зураг зүйн цахим системийн үйлчилгээний хураамж.

14.7.Геодези, зураг зүйн норм, нормативын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааны журмыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага боловсруулж, батлан, хэрэгжилтийг зохион байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

15 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

15.1.Улсын Их Хурал геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаарх төрийн бодлогыг тодорхойлох;

15.1.2.улсын хилийн шугамын дагуух байр зүйн зураг, хилийн тэмдэгтийн солбицол, өндөр, хилийн цэсийг батлах;

15.1.3.энэ хуулийн 11.1.1-11.1.2-т заасан газар зүйн нэрийг батлах, өөрчлөх;

15.1.4.1:25000-аас багагүй масштабтай газрын зурагт дүрсэлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зураг, солбицлын жагсаалтыг батлах;

15.1.5.геодези, зураг зүйн тоон мэдээлэл, байр зүйн зургийн нууцын зэрэглэл тогтоох, нууцыг ил болгох.

16 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

16.1.Засгийн газар геодези, зураг зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.төрөөс геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, геодези, зураг зүйн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

16.1.2.геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах солбицол, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоо, тусгаг, солбицлын эрин, эллипсоид, геодезийн эхлэл цэгийн өгөгдөхүүнийг батлах, геодезийн сүлжээний эхлэл цэгийг хамгаалалтад авах;

16.1.3.олон улсын баримт бичигт тусгах, газрын зурагт хэрэглэгдэх Монгол Улсын газар зүйн нэр, улсын болон засаг захиргааны нэгжийн хил, түүний өөрчлөлтийн талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллагатай солилцох;

16.1.4.газар зүйн нэрийн Үндэсний зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах;

16.1.5.газар зүйн нэрийг тодотгох, шинээр тогтоох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох журам батлах;

16.1.6.энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.16 дахь хэсэгт заасан журам батлах;

16.1.7.хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээний дагуу улсын хилийн шугамыг хамтран шалгах, хилийн бүсэд агаарын зураг авах, байр зүйн зураг үйлдэх ажлыг удирдан зохион байгуулах;

16.1.8.улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлыг зохион байгуулах журам батлах;

16.1.9.олон улсын гэрээгээр геодези, зураг зүйн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

16.1.10.геодези, зураг зүйн салбарын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх;

16.1.11.Монгол Улсын нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ, хилийн шугамын урт, хамгийн өндөр, нам цэг, төв цэг, онцлох цэг, захын цэгүүдийн солбицол, өндөр, захын цэгүүдийн хоорондын зайг батлах.

17 дугаар зүйл.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

17.1.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1.геодези, зураг зүйн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

17.1.2.энэ хуулийн 5.1.1-5.1.37-д заасан үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, үнэлэлт өгөх, мэргэжлийн дүгнэлт гаргах;

17.1.3.энэ хуулийн 5.1-д заасан геодези, зураг зүйн үйл ажиллагаанд баримтлах жишиг үнэ, норм, нормативын баримт бичгийг боловсруулах ажлыг зохион байгуулах, батлах, мөрдүүлэх;

17.1.4.геодези, зураг зүйн ажилд магадлал хийх иргэнийг нээлттэй сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох;

17.1.5.хуулийн этгээдэд геодезийн болон зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

17.1.6.геодези, зураг зүйн салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм батлах;

17.1.7.геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх давтан сургалт зохион байгуулах, зөвлөх, мэргэшсэн инженерийн зэрэг олгох;

17.1.8.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, ажлын даалгавар боловсруулах ажлыг зохион байгуулах, батлах, хэрэгжүүлэх;

17.1.9.геодези, зураг зүйн салбарын боловсон хүчний бодлогыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тодорхойлж, хэрэгжүүлэх;

17.1.10.геодези, зураг зүйн ажилд магадлал, захиалагчийн техникийн хяналт хийх журам батлах;

17.1.11.зөвлөх үйлчилгээ үзүүлэх, захиалагчийн техникийн хяналт, магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлан хэмжилт хийх;

17.1.12.геодезийн цэг, тэмдэгтийн өгөгдөл, мэдээллийн бүрдэл, тооллого, үнэлгээ, мониторинг хийх журам батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

17.1.13.геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлал, загварыг турших, үр дүнг баталгаажуулах журам батлах;

17.1.14.геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлал, загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран турших, үр дүнг цахим системээр дамжуулан баталгаажуулах;

17.1.15.олон улсын геодезийн хэмжилт, зураглалын ажилд оролцох;

17.1.16.геодезийн хэмжилтийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх, хэвийн ажиллагааг хангах, ашиглуулах;

17.1.17.тусгай зориулалтын байр зүйн зургийн зохиолт, хэвлэлт, ашиглалт, тэдгээрийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг эрх бүхий байгууллагатай хамтран хянах, шалгах;

17.1.18.сургалт, нийтийн хэрэгцээний газрын зураг, атлас, үндэсний атлас зохиох, шинэчлэх, хэвлэх, хэрэглээнд гаргах ажлыг зохион байгуулах;

17.1.19.геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, баталгаажуулах ажлыг зохион байгуулах, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг бүртгэх мэдээллийн сан хөтлөх, геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, засварлах, тохируулах, баталгаажуулах;

17.1.20.газрын зургийн нэг маягийн суурь зохиох, батлах, шинэчлэх ажлыг зохион байгуулах;

17.1.21.бүх төрлийн сэдэвчилсэн газрын зураг, атласын хэвлэлийн эхэд магадлал хийлгэх, хэвлэх зөвшөөрөл олгох;

17.1.22.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлыг Монгол Улсын нэрийн өмнөөс шалгаж хүлээн авч геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөгт төвлөрүүлэх;

17.1.23.геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөг, системийг хөтлөх, бүрдүүлэх, баяжуулах, хамгаалах, нэгдсэн сангийн мэдээллээр хангах, олгох, шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, хэрэгжилтийг тайлагнах;

17.1.24.энэ хуулийн 23.4 дэх хэсэгт заасан геодезийн болон зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тухайн жилд ирүүлэх тайлангийн загварыг батлах, тайланд тусгасан геодези, зураг зүйн ажлын үр дүн геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөгт орсон эсэхэд хяналт тавих;

17.1.25.энэ хуулийн 27.2 дахь хэсэгт заасан журам батлах;

17.1.26.гадаад улсын зохиож, хэвлэсэн, олон нийтийн сүлжээнд нийтэлсэн газрын зураг, атлас, сурах бичиг, сэтгүүл, ном, товхимол, илтгэлд тусгагдаж байгаа Монгол Улсын газрын зураг, газар зүйн оноосон нэрийг зөв хэрэглэж байгаа эсэхийг хянах, шалгах, залруулга хийлгэх асуудлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

17.1.27.геодезийн сүлжээний солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгалын утга, солбицол, өндөр, хүндийн хүчний тогтолцооны эрин хоорондын хурдны утгыг батлах, хэрэглээнд нэвтрүүлэх;

17.1.28.цаг үеийн хэрэгцээ шаардлага, шинэ техник технологи нэвтрүүлэхтэй холбогдуулан мэргэжил, мэргэших чиглэлийг тодорхойлох;

17.1.29.хариуцсан асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх санал гаргах, олон улс, бүс нутаг, гадаад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, геодези, зураг зүйн ажлын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх;

17.1.30.улсын хилийн хэмжилт, зураглалын асуудал хариуцсан нэгжтэй байх.

17.2.Санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн геодези, зураг зүйн ажлын үнийн индекс батлана.

17.3.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл агуулсан газрын зургийн зохиолт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах бөгөөд төрийн хамгаалалтад байна.

17.4.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлд нэгжтэй, сум, дүүрэгт мэргэжилтэнтэй байна.

17.5.Геодези, зураг зүйн шинжлэх ухаан, технологийн судалгаа, шинжилгээг шинжлэх ухааны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

17.6.Салбарын албан хаагчдыг төрийн одон, медаль, Засгийн газрын шагналаар шагнуулах мэргэжлийн төрийн бус байгууллагын хүсэлтийг хүлээн авч уламжилна.

18 дугаар зүйл.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

18.1.Бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага геодези, зураг зүйн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

18.1.1.геодези, зураг зүйн хууль тогтоомжийн биелэлтийг харьяалсан салбартаа зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчлах;

18.1.2.салбарын хэмжээнд хийгдэх геодези, зураг зүйн ажлын саналыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор хүргүүлэх;

18.1.3.өөрийн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын техник эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, ажлын даалгавар боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хүлээн авах, Захиалагчийн техникийн хяналт, магадлал хийх, норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх ажлыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

18.1.4.салбарын төлөвлөлтийн зураг зохиох, салбарын орон зайн мэдээллийн сан байгуулахдаа геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн систем, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд байгаа суурь газрын зураг, өгөгдөл, мэдээллийг ашиглах;

18.1.5.энэ хуулийн 27.6-д заасан салбарын өгөгдөл, мэдээллийг газрын зурагт тусгуулахаар геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх;

18.1.6.салбарт хийгдэх ажлын геодезийн хэмжилт, зураглалын зардлыг тухайн ажлын төсөвт өртөгт тусгах.

18.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын газрын зураг, атласын хэрэгцээ, шаардлага, агуулгыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран батална.

18.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь геодези, зураг зүйн шинжлэх ухаан, газрын зургийн талаар сурах бичигт тусгахад геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

18.4.Төрийн байгууллага байнгын ажиллагаатай суурин станц байгуулж, ашиглах бол геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

18.5.Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага нь цэргийн зориулалтаар хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавина.

19 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүрэг

19.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга геодези, зураг зүйн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1.геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

19.1.2.нутаг дэвсгэртээ хамаарах байр зүйн зураг, зураг зүйн бүтээлд тусгах газар зүйн нэр, хил, шинээр бий болсон, өөрчлөгдсөн объектын талаарх мэдээлэл, нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, хот, суурин газрын төвд байрлах геодезийн цэг, тэмдэгтэд жил бүр тооллого хийж тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдээлэх;

19.1.3.геодезийн болон зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий хуулийн этгээдийн харьяа нутаг дэвсгэрт нь хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавих;

19.1.4.нутаг дэвсгэртээ хамаарах батлагдсан газар зүйн нэрийн хэрэглээнд хяналт тавих, шинэ нэрийн талаар санал гаргах;

19.1.5.нутаг дэвсгэртээ хамаарах газрын зургийг гүйцэтгэлийн зургаар шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

19.1.6.орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геодези, газрын зургийн ажлыг төлөвлөх, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар хянуулах, хамтран батлах;

19.1.7.энэ хуулийн 10.10, 10.11-д заасан үйл ажиллагаа, геодезийн цэг, тэмдэгтийг дөрвөн жил тутам тоолох, бүртгэх, хамгаалах, нөхөн сэргээх зардлыг санхүүжүүлэх;

19.1.8.орон нутгийн төсвөөр гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүнд захиалагчийн техникийн хяналт хийлгэх;

19.1.9.нутаг дэвсгэртээ хамаарах том масштабын газрын зургийн жижүүрийн зургийг хөтлөх ажлыг зохион байгуулах.

20 дугаар зүйл.Төрийн бус байгууллагын оролцоо

20.1.Энэ хуулийн 17.1.5, 17.1.7, 17.1.11, 17.1.19-д заасан зарим чиг үүрэг, шаардлагатай тохиолдолд тухайлсан үйл ажиллагааг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан чиг үүргийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн⁶ 19 дүгээр зүйлд заасны дагуу мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

⁶ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

20.3.Мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл Газар зүйн нэрийн үндэсний зөвлөл, геодези, зураг зүйн салбарын мэргэжлийн зөвлөл, ажлын хэсэгт орж хамтран ажиллана.

21 дүгээр зүйл.Захиалагчийн чиг үүрэг

21.1.Геодези, зураг зүйн ажил захиалагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.1.1.тухайн нутаг дэвсгэрт явуулж буй геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаар засаг захиргаанд мэдэгдэх;

21.1.2.геодези, зураг зүйн ажлын захиалагч нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр геодези, зураг зүйн ажлын үр дүн, газрын зургийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан, хөмрөгт үнэ төлбөргүй шилжүүлэх;

21.1.3.энэ хуулийн 26.4-д заасан нэгдсэн сан дахь суурь мэдээллийг ашиглах;

21.1.4.энэ хуулийн 26.7-д заасан мэдээллийг бүрдүүлэх;

21.1.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангах арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох зардлыг хариуцах;

21.1.6.геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал, захиалагчийн техникийн хяналт хийлгэх, холбогдох зардлыг хариуцах;

21.1.7.геодези, зураг зүйн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын асуудлыг хариуцаж, санхүүжилтийг тогтоосон хугацаанд хийх.

21.2.Тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зургийн захиалагч нь эрх бүхий этгээд байна.

22 дугаар зүйл.Хүн, хуулийн этгээдийн үүрэг

22.1.Геодези, зураг зүйн тухай болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, норм, нормативын баримт бичгийг үйл ажиллагаандаа баримтална.

22.2.Улсын Их Хурал баталсан газар зүйн нэрээр уул ус, газар нутгаа зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, оноосон нэрийг монгол хэлнээс бусад хэлээр орчуулах, бусад хэлний дуудлагаар галиглахгүй байна.

22.3.Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хуулийн этгээд нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, төслийн хөрөнгөөр геодезийн цэг, тэмдэгт байгуулсан бол уг цэгийн байрлаж байгаа сум, дүүргийн Засаг дарга, тусгай хэрэгцээний газарт бол хариуцсан захирагчийн, хилийн зурваст бол хил хамгаалах байгууллагын харьяа тусгай ангийн хамгаалалтад хүлээлгэж өгнө.

22.4.Хүн, хуулийн этгээд нь шинээр барьсан, өргөтгөсөн, шинэчилсэн инженерийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх, ашиглахаас өмнө гүйцэтгэлийн зураг хийлгэж, төвөгшилтэй барилга байгууламжийн хэв гажилтын мониторингийн үр дүнг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан, хөмрөгт үнэ төлбөргүй шилжүүлэх үүрэгтэй.

22.5.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд Зөвшөөрлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлд зааснаас гадна дараах үүрэгтэй:

22.5.1.геодезийн хэмжих хэрэгсэлд жил тутамд, эвдрэл, гэмтэл гарсан нөхцөлд тухай бүр баталгаажуулалт хийлгэх;

22.5.2.геодезийн хэмжилт, зураглалыг батлагдсан солбицол, өндөр, гравиметрийн нэгдсэн тогтолцоо, эрин, тусгагт хийх;

22.5.3.солбицлын дэд тогтолцоо үүсгэж геодезийн хэмжилт, зураглалыг гүйцэтгэсэн бол солбицлын нэгдсэн тогтолцоонд холбох хөрвүүлэлтийн утгыг тодорхойлон батлуулах;

22.5.4.төрөл бүрийн сэдэвчилсэн, лавлагааны, сургалтын газрын зураг, атлас зохиохдоо газрын зургийн нэг маягийн суурь зураг ашигласан байх;

22.5.5.гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүнгийн үнэн, зөв байдлыг хариуцах;

22.5.6.геодезийн хэмжилт, зураглалын ажилд ашигласан солбицол, өндөр, хүндийн хүчний хурдатгал, тоон зураг, мэдээлэл, эх сурвалжийг нарийвчлалын үзүүлэлтийн хамт ажлын тайланд тусгах.

22.6.Сурах бичиг болон ном товхимол, тайлан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзүүлэх улс, аймгийн хилийн шугам, газар нутаг, хот суурины нэр зэрэг зураг зүйн суурь мэдээ, мэдээллийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан дахь мэдээлэлд үндэслэн гүйцэтгэж, алдаагүй хэвлэж, түгээнэ.

22.7.Байнгын ажиллагаатай суурин станц байгуулж, ашиглах бол геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөнө.

22.8.Газрын зураг, атлас хэвлэхдээ геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн дүгнэлт гаргуулсан байна.

22.9.Геодезийн хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх бол геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

22.10.Геодезийн хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, хэмжилтийн нарийвчлалыг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах, шалгалт, тохируулга хийх, баталгаажуулалтад хамруулна.

22.11.Энэ хуулийн 17.1.14-д заасан туршилтад хамрагдаагүй, баталгаажуулалт хийгдээгүй геодезийн хэмжих хэрэгсэл ашиглахыг хориглоно.

22.12.Хүн хуулийн этгээдийн геодези, зураг зүйн үйл ажиллагаанаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг буруутай этгээд хариуцна.

23 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл

23.1.Геодези, зураг зүйн салбарын тусгай зөвшөөрлийг геодезийн, зураг зүйн гэж хоёр төрлөөр таван жилийн хугацаатай олгоно, мөн хугацаагаар сунгана.

23.2.Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд дараах суурь нөхцөл, шаардлагыг хангасан байна:

23.2.1.геодезийн бакалавр зэрэгтэй хоёроос доошгүй инженертэй, нэг инженер нь зөвлөх, эсхүл мэргэшсэн зэрэгтэй байх;

23.2.2.өөрийн эзэмшлийн таван секундээс багагүй нарийвчлалтай геодезийн хэмжилтийн цахим тахеометр, хиймэл дагуулаас байрлал тодорхойлох хоёр долгионы хүлээн авагч, антенн, гурван миллиметрээс багагүй хэмжилтийн нарийвчлалтай нивелиртэй байх.

23.3.Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээд нь зураг зүйн зөвлөх, эсхүл мэргэшсэн зэрэгтэй инженертэй, боловсруулалтын техник, программ хангамжтай байна.

23.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жил гүйцэтгэсэн ажлын тайланг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

23.5.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг хянаж, дараа оны нэгдүгээр улиралд багтаан гэрээ дүгнэсэн актыг цахим системд байршуулна.

23.6.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн, инженер, техникийн ажилтны, хэмжих хэрэгслийн мэдээллийн санг хөтөлнө.

23.7.Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох цахим системийн үйл ажиллагааны журам, тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

23.8.Гадаадын иргэн, хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

23.9.Энэ хуулийн 23.2.1, 23.3-т заасан инженерүүд нь тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн үндсэн ажилтан байх ба хэмжих хэрэгсэл болон инженер нь мэдээллийн сангийн бүртгэлд давхцалгүй байна.

23.10.Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн⁷ дагуу үйл ажиллагааны баримтын архив үүсгэж, хадгална.

23.11.Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд татан буугдахад архивын баримтыг салбарын төрийн архивд шилжүүлэх үүрэгтэй.

23.12.Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгалалтын хугацаа дууссан баримтыг салбарын төрийн архивд шилжүүлэх үүрэгтэй.

23.13.Тусгай зөвшөөрөл хүсэх, хүсэлтийг хүлээн авах, баримтыг хянах, тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, гэрчилгээг нөхөн олгохтой холбогдсон харилцааг цахим системээр дамжуулан зохион байгуулах ба олон нийтэд ил тод, нээлттэй байна.

23.14.Тусгай зөвшөөрөл хүсэх, олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд⁸ заасан журамд нийцүүлэн зохион байгуулна.

23.15.Дараах тохиолдолд хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

23.15.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дахь зүйлийн нөхцөл байдал үүссэн;

23.15.2.тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ хоёроос дээш удаа биелүүлээгүй;

23.15.3.захиалагчтай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүн нь холбогдох норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангаагүйгээс захиалагчид хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

23.15.4.геодези, зураг зүйн ажлын үр дүн алдаатай болохыг тогтоосон эрх бүхий байгууллагын дүгнэлт гарсан;

23.15.5.гүйцэтгэсэн ажлын мэдээ, тайланг хоёр жилээс дээш хугацаанд цахим системд ирүүлээгүй;

23.15.6.энэ хуулийн 23.2, 23.3-т заасан суурь нөхцөл, шаардлага хангагдаагүй нь тогтоогдсон.

23.16.Гадаадын иргэн, хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

23.17.Энэ хуулийн 23.2, 23.3, 23.9 дэх хэсгийг хангахгүй болсон нь тогтоогдсон, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл үүссэн бол тусгай зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

⁷Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

⁸Зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.

23.18.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

23.19.Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлтийг, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт цахим системээр дамжуулан гаргана.

23.20.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, энэ хуулийн 23.19-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд тухайн зөвшөөрөл эзэмшиж байсан этгээдээс зургаан сарын дотор тусгай зөвшөөрлийг дахин хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

23.21.Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд геодезийн болон зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

24 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн төрийн хяналт

24.1.Геодези, зураг зүйн улсын хяналтыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

24.2.Энэ хуулийн 24.1-д заасан хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4-д заасны дагуу геодези, зураг зүйн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч гүйцэтгэнэ.

24.3.Геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчаар геодези, зураг зүйн мэргэжилтэй, мэргэжлээрээ гурав ба түүнээс дээш жил ажилласан дадлага, туршлагатай иргэнийг томилно.

25 дугаар зүйл.Геодези, зураг зүйн ажилд магадлал, магадлан хэмжилт, захиалагчийн техникийн хяналт хийх

25.1.Магадлалыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар гүйцэтгэх геодези, зураг зүйн ажлын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, инженерийн барилга байгууламжийн зураг төсөлд зориулсан байр зүйн, дэвсгэр, гүйцэтгэлийн, өндөржилтийн, улаан шугамын зураг, ажлын төсөв, даалгавар, сэдэвчилсэн газрын зураг, атласын зохиолтын болон хэвлэлийн эхэд хийж дүгнэлт гаргана.

25.2.Геодези, зураг зүйн ажилд магадлалыг эрх бүхий эксперт энэ хуулийн 17.1.10-д заасан журмын дагуу гүйцэтгэнэ.

25.3.Магадлалыг энэ хуулийн 5.1.1, 5.1.3, 5.1.5, 5.1.7, 5.1.12, 5.1.13, 5.1.15, 5.1.16, 5.1.17, 5.1.19, 5.1.25, 5.1.29, 5.1.36-д заасан үйл ажиллагаанд хийнэ.

25.4.Магадлан хэмжилт, захиалагчийн техникийн хяналтыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

25.5.Захиалагчийн техникийн хяналтыг энэ хуулийн 5.1.3, 5.1.5, 5.1.7, 5.1.12, 5.1.15, 5.1.16, 5.1.19, 5.1.25, 5.1.29-д заасан үйл ажиллагаанд хийнэ.

25.6.Захиалагчийн техникийн хяналт, магадлалын дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлж болно.

25.7.Захиалагч нь хүсэлт гаргасан тохиолдолд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн геодезийн хэмжилт, зураглалын ажилд магадлан хэмжилт хийж болох ба зардлыг захиалагч хариуцна.

25.8.Захиалагчийн техникийн хяналтын зардлыг уг ажлын захиалагчийн хяналтын зардлаас тооцож санхүүжүүлнэ.

25.9.Захиалагчийн техникийн хяналтаар илэрсэн алдаа, дутагдлыг гүйцэтгэгч хариуцан засварлана.

ТАВДУГААР БҮЛЭГ ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН БАРИМТ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО

26 дугаар зүйл.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөг

26.1.Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөг /цаашид “нэгдсэн сан хөмрөг” гэх/ нь геодезийн сүлжээний тайлан, мэдээлэл, газрын зураг, газрын зургийн нэг маягийн суурь, агаар, сансрын зураг, газар зүйн нэр, геодезийн цэг, тэмдэгт, тэдгээртэй холбогдох бусад тоон баримт мэдээллээс бүрдэнэ. Нэгдсэн сан хөмрөг нь төрийн өмч байна.

26.2.Хүн, хуулийн этгээд нь гадаадын зээл, тусламж, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, хувийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт, хэвлэмэл болон тоон газрын зураг, дүрс болон дуу бичлэг, тоон мэдээллийг нэгдсэн сан хөмрөгт шилжүүлэх үүрэгтэй.

26.3.Геодези, зураг зүйн өгөгдөл, бүтээгдэхүүнийг нэгдсэн портал сайтаар дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэнэ.

26.4.Нэгдсэн сан хөмрөг нь дараах тоон болон цаасан өгөгдөл, мэдээллээс бүрдэнэ:

26.4.1.энэ хуулийн 5.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны үр дүнд үүссэн газрын зураг, хэвлэлийн эх, гэрэл зургийн хальс, дуу, дүрс бичлэг, тайлан, солбицлын жагсаалт, бусад баримт мэдээлэл;

26.4.2.энэ хуулийн 26.2-т заасны дагуу хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт мэдээлэл;

26.4.3.энэ хуулийн 26.4.1, 26.4.2-т зааснаас бусад, худалдах, олшруулах эрхгүйгээр хүн, хуулийн этгээдээс авсан, худалдан авсан баримт мэдээлэл;

26.4.4.хүн, хуулийн этгээдээс өөрсдийн үйл ажиллагаа, бүтээлийг сурталчлах зорилгоор нэгдсэн санд ирүүлж байгаа зураг, тоон мэдээлэл, тоног төхөөрөмжийн тухай танилцуулга.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан мэдээллийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, нийтэд үйлчлэх журмыг энэ хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль⁹ болон Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай¹⁰, Кибер аюулгүй байдлын тухай хуульд¹¹ нийцүүлэн геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, мөрдүүлнэ.

26.6.Нэгдсэн сан хөмрөгийн мэдээллийн мета-өгөгдлийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийтэд мэдээлэх үүрэгтэй.

⁹Төрийн болон албаны нууцын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

¹⁰Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 06 дугаарт нийтлэгдсэн.

¹¹Кибер аюулгүй байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

26.7.Нэгдсэн сан хөмрөгийн мета-өгөгдөл нь дараах мэдээллээс бүрдэнэ:

- 26.7.1.мэдээллийн нэр, товч тайлбар;
- 26.7.2.мэдээллийн чанарын тодорхойлолт;
- 26.7.3.мэдээллийн үндсэн эх сурвалж;
- 26.7.4.мэдээллийн дүрслэл, солбицлын тогтолцоо;
- 26.7.5.мэдээллийн хэрэглээ, түгээлт.

26.8.Хүн, хуулийн этгээд нь энэ хуулийн 26.4.2-т заасан мэдээллийг мета-өгөгдлийн хамт ажлын үр дүнг захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөгт шилжүүлэх үүрэгтэй.

26.9.Хүн, хуулийн этгээдийн гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүнг мэргэжлийн дүгнэлтийг үндэслэн нэгдсэн сан хөмрөгт актаар хүлээн авна.

26.10.Хүн, хуулийн этгээд нь газрын зураг захиалж хийлгэхдээ урьд өмнө нь тухайн газар нутагт геодези, зураг зүйн ажил хийгдэж байсан эсэхийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сан хөмрөгөөс нягтална.

26.11.Улсын төсвөөр хийгдсэн ажилд ашигласан геодези, зураг зүйн мэдээллийн сан хөмрөгийн өгөгдлийг бусдад дамжуулах, түүнийг ашиглаж геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

26.12.Хүн, хуулийн этгээд нь геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөгт ороогүй мэдээ, мэдээллийг геодези, зураг зүйн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

26.13.Монгол Улсын нутаг дэвсгэрт олон улсын зээл тусламж, хөтөлбөр, төслөөр хийгдсэн геодези, зураг зүйн ажлын өгөгдөл, мэдээлэл, үр дүн, газрын зураг нь төрийн өмч байна.

27 дугаар зүйл.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн систем

27.1.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн систем нь дараах дэд систем, сангуудаас бүрдэнэ:

- 27.1.1.газрын зургийн мэдээллийн дэд систем;
- 27.1.2.геодезийн сүлжээний цэг, тэмдэгтийн мэдээллийн дэд систем;
- 27.1.3.газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем;
- 27.1.4.улсын хилийн мэдээллийн дэд систем;
- 27.1.5.геодезийн хэмжих хэрэгслийн багаж баталгаажуулах дэд систем;
- 27.1.6.геодези, зураг зүйн мэргэжилтний мэдээллийн сан;
- 27.1.7.байнгын ажиллагаатай суурин станцын өгөгдлийн сан;
- 27.1.8.тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн мэдээллийн дэд систем,
- 27.1.9.геодезийн сүлжээний хэмжилтийн өгөгдөл, боловсруулалтын дэд систем.

27.2.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн систем нь Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн суурь мэдээллийн систем байх бөгөөд шинэчлэлт, өөрчлөлтийн зохицуулалтыг журмаар тогтооно.

27.3.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн системийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэн хөтөлж, хадгалж, хамгаалж, нэгдсэн удирдлага, хяналт, зохион байгуулалтаар хангана.

27.4.Аймаг, нийслэлийн геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байр зүйн болон дэвсгэр зургийн шинэчлэлтийг хөтөлж, геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн системд оруулна.

27.5.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн системд агуулагдах геодези, зураг зүйн өгөгдөл, мэдээлэл, газрын зургаар хэрэглэгчийг хангана.

27.6.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн системд агуулагдах өгөгдөл, мэдээлэл нь авто зам, төмөр зам, эрчим хүч, барилга, хот байгуулалт, ус, ой, харилцаа холбоо, байгаль орчин, уул уурхайн салбарын мэдээллээр шинэчлэгдэж, мэдээллээ харилцан солилцдог байна.

27.7.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн системд агуулагдах газрын зургийг гүйцэтгэлийн зургаар шинэчилнэ.

27.8.Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн системд агуулагдах өгөгдөл, мэдээллийг бусад цахим системд бүрдүүлэх, шинэчлэх, түүгээр үйлчлэхийг хориглоно.

27.9.Геодезийн хэмжих хэрэгслийн багаж баталгаажуулах дэд систем дэх геодезийн хэмжих хэрэгсэл эзэмшигчийн мэдээллийг үндэслэлгүйгээр солих, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээг хуурамчаар үйлдэхийг хориглоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ, ХАРИУЦЛАГА

28 дугаар зүйл.Санхүүжилт

28.1.Геодези, зураг зүйн ажлыг улсын болон орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлнэ.

28.2.Улсын геодезийн сүлжээ байгуулах, нягтруулах, давтан хэмжих, геодезийн цэг, тэмдэгтийг тоолох, нөхөн сэргээх, дунд болон жижиг масштабын байр зүйн, газар зүйн нэрийн, сургалтын, сэдэвчилсэн газрын зураг, атлас, альбом, тайлбар толь бичиг, жагсаалт, Үндэсний атлас зохиох, шинэчлэх, хэвлэх ажлын захиалагч нь геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байх бөгөөд зардлыг жил бүр улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

28.3.Тухайн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч нь холбогдох төрийн захиргааны байгууллага, орон нутагт хийгдэх геодези, зураг зүйн ажлын захиалагч нь тухайн шатны Засаг дарга байна.

28.4.Том масштабын байр зүйн болон дэвсгэр зураг зохиох, шинэчлэх, геодезийн сүлжээ байгуулах, цэг тэмдэгтийг хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

28.5.Хүн, хуулийн этгээдийн захиалгаар хийгдэх геодези, зураг зүйн ажлыг захиалагчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

28.6.Энэ хуулийн 22.4-д заасан гүйцэтгэлийн зураг хийлгэхэд шаардагдах зардлыг захиалагч хүн, хуулийн этгээд хариуцна.

28.7.Энэ хуулийн 14.1-д заасан геодези, зураг зүйн норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, хэвлэх, сурталчлах зэрэг үйл ажиллагааны зардлыг 14.5-д заасан сангаас санхүүжүүлнэ.

28.8.Улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа геодези, зураг зүйн ажлын нийт төсөвт өртгийн зургаан хувийг захиалагчийн техникийн хяналт, магадлалд зарцуулна.

28.9.Геодезийн хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын орлогыг хэмжих хэрэгслийг баталгаажуулах үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах, тохируулга хийх үйл ажиллагааг сайжруулах, геодези, зураг зүйн техникийн зохицуулалт, норм, стандарт боловсруулах, хэвлэж олшруулах, сурталчлах үйл ажиллагаанд зарцуулна.

29 дүгээр зүйл.Хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд¹² заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹³, эсхүл Зөрчлийн тухай хуульд¹⁴ заасан хариуцлага хүлээлгэнэ.

30 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

30.1.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө хууль тогтоомжийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрөл нь тухайн гэрчилгээнд заасан хугацаа дуустал хүчин төгөлдөр байна.

30.2.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө ирүүлсэн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг шинэ хуулийн дагуу шийдвэрлэнэ.

30.3.Энэ хуульд заасан норм, нормативын баримт бичгүүдийг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 18 сарын хугацаанд шинээр болон шинэчлэн боловсруулж батлах бөгөөд тэдгээрийг батлагдах хүртэлх хугацаанд тухайн харилцааг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм, журам, норм, нормативын баримт бичгээр зохицуулна.

31 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

31.1.Энэ хуулийг 20... оны ..дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

¹²Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 01 дүгээрт нийтлэгдсэн.

¹³Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 05 дугаарт нийтлэгдсэн

¹⁴Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дүгээрт нийтлэгдсэн